МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЕРӨНХИЙ БОЛОН СОРИЛЫН БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/197/СТА-ТШЗ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2018 он

ҮАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# ЕРӨНХИЙ БОЛОН СОРИЛЫН БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Аудитын тайлан


**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараахь хаягаар харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл
Утас: 261885
Цахим хаяг:
oyungerelts@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэндорж
Утас: 261740
Цахим хаяг:
tserendorjd@audit.gov.mn

Монгол Улсын
Үндэсний аудитын газар:
*Засгийн газрын IY байр*
*Улаанбаатар-15160*
*Бага тойруу 3*, Чингэлтэй дүүрэг
Вэб хуудас: www.audit.mn

"Мэдээлэл-Аудит" ХХК
*БГД, 18-р хороо,*
*Sky apartment, 4 давхар, 19 тоот*
*Захирал: Д.Товуудорж*
Утас:70159511
Вэб хуудас: medeelelaudit@gmail.com


АГУУЛГА


*Хавсралт 1: Аудитын гэрчилгээ*

*Хавсралт 2: Аудитын тайлан*

*Хавсралт 3: Менежментийн захидал*

*Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан*

*Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан*


01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

# АГУУЛГА


| | | |
|---|---|---|
| 1 | Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл | 2 |
| 2 | Байгууллагын хууль, эрх зүйн орчин | 3 |
| 3 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа | 3 |
| 4 | Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн | 4 |
| 5 | Дотоод хяналт | 4 |
| 6 | Материаллаг түвшин | 5 |
| 7 | Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар | 5 |
| 8 | Шилэн дансны мэдээлэл | 5 |
| 9 | Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар | 5 |
| 10 | Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар | 5 |
| 11 | Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар | 6 |
| 12 | Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар | 6 |
| 13 | Анхаарал татахуйц бусад чухал асуудал | 7 |
| 14 | Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд | 7 |
| 15 | Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл | 7 |
| 16 | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 7 |
| 17 | Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт | 7 |
| 18 | Менежментийн захидал | 8-12 |
| 19 | Аудитлагдсан санхүүгийн тайлан | 13-18 |
| 20 | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | 19-20 |
| 21 | Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан | 21 |


01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/513

танай ____________-ны № ____________-т

ЕРӨНХИЙ БОЛОН СОРИЛЫН
БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Я.АДЪЯА ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0223SAG113.Docx

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

020656

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0223SAG113.Docx

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд ҮАГ-САГ/2018/197/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 23-наас 2 дугаар сарын 21–ны хооронд хийхээр төлөвлөн, “Мэдээлэл Аудит” ХХК-ийн ахлах аудитор Н.Ганданбаавараар удирдуулсан аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 22–ны өдөр "Мэдээлэл-Аудит" ХХК –д ирүүлсэн.

"Мэдээлэл-Аудит" ХХК нь Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 23–ны өдрөөс 2018 оны 2 дугаар сарын 21–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23–ний өдөр Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн удирдлагад гардуулна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн төсвийн захирагч нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн аудитын тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын багц, Татварын багц хуулиуд болон "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2014 оны 75, 208, 78 дугаар тогтоол, "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" Засгийн газрын 2011 оны 311 дугаар тогтоолууд болон холбогдох дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

## Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны "Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" 27 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газар, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдын 2015 оны 9 сарын 2-ны өдрийн А/337 дугаар тушаалд ШУА-ийн Ерөнхий болон Сорилын Биологийн Хүрээлэнгийн үйл ажиллагааны дараах чиглэлийг тогтоожээ. Үүнд:

- Монгол орны амьтаны аймгийн биологи, экологи онцлог, антропогенийн болон уур амьсгалын өөрчлөлт, амьтны аймагт нөлөөлөх зүй тогтлыг судлан илрүүлж, амьд байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хадгалах, нөөц баялагийг хамгаалах, тогтвортой ашиглах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах
- Монгол орны амьтны гарал үүслийг тогтоох, генийн сан бүрдүүлэх, сэргээн үржүүлэх генетик үндэслэл боловсруулах, эмийн болон ганд тэсвэртэй ургамлыг биотехнологийн аргаар үржүүлэх хоёрдогч метаболитын судалгаа хийх, хавдрын эсийг дарангуйлах ургамлын гаралтай биологийн идэвхит бодисыг судлах, хавдрын молекул механизм, шалтгааныг тогтоох, оношлогооны цомог гарган авах, хувиргасан амьд организмыг илрүүлэх
- Монгол орны бичил биетний ангилал зүй, генетик нөөцийг судалж, бичил биетний үндэсний сан бий болгох, инноваци, биотехнологийн тэтгэх ашигт өсгөврүүдийг илрүүлж, байгаль орчны бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх, хөрс сайжруулах, фермент хүнс, тэжээлийн нэмэлт бэлдмэл, өвчин үүсгэгчийн эсрэг үйлчилгээтэй бүтээгдэхүүн гарган авах

Монгол орны ургамлын аймгийн олон янз байдал, нөөцийг тогтоох, хамгаалах, тогтвортой ашиглах, уур амьсгалын өөрчлөлт, хүний ба бусад хүчин зүйлсийн ургамал нөмрөг дэх нөлөөллийг үнэлэх, нөхөн сэргээх, дотоод гадаадын гоёл чимэглэлийн, ашигт, ховор ургамлыг нутагшуулах, тарималжуулах, дасан зохицох механизмыг тогтоох, ган, хүйтэн, өвчинд тэсвэртэй ургамлын суулгац, шинэ сортуудыг гаргаж авах зэрэг чиг үүрэгтэй.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлэн ажилласан.

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

## Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 5-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар батлагдсан, УСНББОУС-тай нийцсэн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх НББББ-ийг мөрдөн ажиллаж, санхүүгийн тайлангаа холбогдох аргачиллын дагуу, санхүүгийн програмаар боловсруулан бэлтгэжээ.

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

### Дотоод хяналт

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн дотоод хяналт хэвийн хангалттай байна.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### Материаллагын түвшин

Мөн материаллаг түвшинг төлөвлөлтийн үед нийт зардлын гүйцэтгэл 2,045,449.1 мянган төгрөгийн 1 хувь буюу 20,454.5 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөөгүй.

### Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 1,795,413.3 мянга, нэмэлт санхүүжилтийн дансаар ШУТС-аас судалгааны зардалд 195,921.0 мянга, дээд шатны байгууллагаас 93,125.8 мянга, нийт 2,084,460.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс үйл ажиллагааны урсгал зардалд 2,077,746.2 мянган төгрөг зарцуулж, төсвийн үлдэгдэл 6,713.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан эсэхэд 2017 оны 11 дүгээр сард нийцлийн аудит хийгдсэн болно.

### Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

### Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлсний тооцоо зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Үндсэн хөрөнгийн тухайд 2017 оны төсвийн жилд эрдэм шинжилгээний зардлаас 19,515.7 мянган төгрөгийн, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр 40,000.0 сая төгрөгийн, БСШУСЯ-аас хөрөнгө оруулалтын зардлаар 9,198.0 төгрөгийн нийтдээ 68,713.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны А-5/3611, 531 дүгээр тогтоолуудаар нийт 113,772.5 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан элэгдэлээрээ өртөгөө нөхсөн үндсэн хөрөнгийг бүртгэлээс хассан байна.

## Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

***Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна***

1. 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Ажилчдаас авах авлага 11,820.0 мянган төгрөг, Байгууллагаас авах авлага 2,252.3 мянган төгрөгийн нийт 14,072.3 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "***төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх***" гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

   Шийдвэрлэсэн: *Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;*

2. 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ХХОАТатварт 4,149.5 мянган төгрөгийн өртэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "***төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх***" гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

   Шийдвэрлэсэн: *Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;*

3. Санхүүгийн тайланд тусгагдсан Төрийн оруулсан капитал, Улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгүүлсэн өөрийн хөрөнгийн хэмжээ хоорондоо 33,120.0 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т *"Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна"*, 11.3-т *"...11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15-ны өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ"* гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

   Шийдвэрлэсэн: *Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;*

## Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын явцад залруулах боломжгүй авлага, өглөгийн тооцоог барагдуулах, улсын бүртгэлийн гэрчилгээнд Засгийн газрын оруулсан капитал-Төрийн өмчийн өөрчлөлтийг бүртгүүлэх талаар зөвлөмж өгсөн.



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

## Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Дараагийн аудитаар анхаарч үзэх анхаарал татах асуудал үгүй байна.

## Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 18,851.8 мянга төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс материаллаг буруу илэрхийлэлгүй тул удирдлагын түвшинд анхаарч ажиллах 3 асуудлаар зөвлөмж өгч ажиллалаа.

## Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд " "И Эс Эс Эс Аудит" ХХК аудит хийсэн бөгөөд ямар нэгэн зөвлөмж өгөгдөөгүй байна.

## Аудитын санал дүгнэлт

Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# ЕРӨНХИЙ БОЛОН СОРИЛЫН БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Менежментийн захидал

**Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:**

***Асуудал 1***
*Авлага талаар* 10

***Асуудал 2***
*Өр төлбөрийн талаар* 11

***Асуудал 3***
*Засгийн газрын оруулсан капиталын талаар* 12

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| Асуудал 1 Авлагын талаар | Тэргүүлэх ач холбогдол №2 |
|---|---|

***Аудитын ажиглалт***

- 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ажилчдаас авах авлага 11,820.0 мянган төгрөг, байгууллагаас авах авлага 2,252.3 мянган төгрөгийн, нийт 14,072.3 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "***төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх***" гэсэн заалтыг мөрдөөгүй.

***Аудитын зөвлөмж***

- Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;
- Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 4 дүгээр сарын 02-ны дотор Мэдээлэл-Аудит ХХК-д ирүүлэх;

***Эрсдэл***

Төсвийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн тайлангийн Эрх ба үүрэг, Толилуулга ба илчлэл тодруулга зэрэг батламж мэдэгдэл зөрчигдөх

***Үйлчлүүлэгчийн хариу***

- *Дээрх зөрчилд зөвлөмж өгснийг холбогдох байгууллага хүлээн зөвшөөрч 2018 оны 2 дугаар сарын 28-ны дотор багтаан хэрэгжүүлэх хариу ирүүлсэн.*

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| **Асуудал 2 Өр төлбөрийн талаар** | **Тэргүүлэх ач холбогдол №2** |
|---|---|

***Аудитын ажиглалт***

- 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ХХОАТатварт 4,149.5 мянган төгрөгийн өр төлбөртэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "***төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх***" гэсэн заалт зөрчигдөж байна.

***Аудитын зөвлөмж***

- Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;
- Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 4 дүгээр сарын 02-ны дотор Мэдээлэл-Аудит ХХК-д ирүүлэх;

***Эрсдэл***

Төсвийн тухай хууль зөрчигдөх, Эрх ба үүрэг, Толилуулга ба илчлэл тодруулга зэрэг батламж мэдэгдэл зөрчигдөх

***Үйлчлүүлэгчийн хариу***

- *Дээрх зөрчилд зөвлөмж өгснийг холбогдох байгууллага хүлээн зөвшөөрч 2018 оны 3 дугаар сарын 30-ны дотор хэрэгжүүлэх хариу ирүүлсэн.*

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**СТ-1А**

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 86,966,613.00 | **107,219,171.12** |
| **33** | **АВЛАГА** | 7,934,000.00 | **14,072,288.12** |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | - | 12,147,288.12 |
| 335 | Бусад авлага | 7,934,000.00 | 1,925,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 7,934,000.00 | 1,925,000.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 7,787,995.00 | - |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 7,787,995.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 71,244,618.00 | **93,146,883.00** |
| **354** | **Хангамжийн материал** | 71,244,618.00 | **93,146,883.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 532,800.00 | 1,574,978.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,343,470.00 | 14,530,640.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 757,000.00 | 757,000.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | - | 352,200.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 64,611,348.00 | 75,932,065.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 1,171,465,678.87 | **1,196,223,135.70** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,171,465,678.87 | **1,196,223,135.70** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,170,695,678.87** | **1,195,092,610.70** |
| 39201 | Барилга, байгууламж | 1,983,232,211.00 | 1,983,232,211.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (990,061,104.71) | (1,008,264,904.81) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 7,626,900.00 | 7,626,900.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (6,626,900.02) | (6,841,185.76) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 621,425,617.00 | 620,790,706.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (468,075,530.80) | (414,851,172.98) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 72,508,501.32 | 63,681,307.14 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (66,252,628.12) | (57,504,252.28) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 565,007,831.00 | 529,031,700.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (555,312,220.19) | (529,031,700.00) |
| 39217 | Номын фонд | 7,223,002.39 | 7,223,002.39 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **770,000.00** | **1,130,525.00** |
| 39301 | Програм хангамж | 3,770,000.00 | 4,149,500.00 |
| 39302 | Хасагдуулга | (3,000,000.00) | (3,018,975.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,258,432,291.87** | **1,303,442,306.82** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **4,279,030.00** | **4,147,346.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **4,279,030.00** | **4,147,346.00** |
| **413** | **Өглөг** | **4,279,030.00** | **4,147,346.00** |
| 4131 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 4,279,030.00 | 4,147,346.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **1,254,153,261.87** | **1,299,294,960.82** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,254,153,261.87** | **1,299,294,960.82** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 1,839,580,969.39 | 1,839,580,969.39 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 1,839,580,969.39 | 1,839,580,969.39 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(1,699,813,926.84)** | **(1,654,672,227.89)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (1,699,813,926.84) | (1,699,813,926.84) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 45,141,698.95 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,114,386,219.32 | 1,114,386,219.32 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **1,258,432,291.87** | **1,303,442,306.82** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**СТ-2А**

## АУДИТ ХИЙГДСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,088,924,389.00** | **2,090,590,819.00** |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **36,150,416.00** | **21,564,700.00** |
| Нийтлэг татварын бус орлого | 36,150,416.00 | 21,564,700.00 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 36,150,416.00 | 21,564,700.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,150,416.00 | 6,366,700.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 9,198,000.00 |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,052,773,973.00** | **2,069,026,119.00** |
| Улсын төвлөрсөн төсвөөс | 1,828,008,200.00 | 1,787,913,300.00 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,828,008,200.00 | 1,787,913,300.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 199,188,000.00 | 281,112,819.00 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | 114,804,000.00 | 60,775,219.00 |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 62,654,000.00 | 208,421,000.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 21,730,000.00 | 11,916,600.00 |
| Нийгмийн даатгалын сангийн төсвөөс | 25,577,773.00 | - |
| Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 25,577,773.00 | - |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **2,044,115,717.68** | **2,045,449,120.05** |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,044,115,717.68 | 1,996,935,239.05 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,044,115,717.68 | 1,996,935,239.05 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,366,195,227.00 | 1,355,126,157.68 |
| Цалин | 1,307,798,427.00 | 1,158,107,057.68 |
| Нэмэгдэл цалин | - | 139,206,300.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 58,396,800.00 | 57,812,800.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 147,870,416.00 | 153,241,700.00 |
| Тэтгэврийн даатгалын шимтгэл | 93,861,486.00 | 103,104,350.00 |
| Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 10,801,306.00 | 12,999,012.00 |
| ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 8,037,178.00 | 10,889,300.00 |
| Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 8,164,484.00 | 2,385,416.00 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 27,005,962.00 | 23,863,622.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 54,230,000.00 | 50,267,600.00 |
| Гэрэл цахилгааны зардал | 35,403,573.00 | 34,633,630.00 |
| Түлш, халаалтын зардал | 14,696,007.00 | 12,626,157.00 |
| Цэвэр, бохир усны зардал | 4,130,420.00 | 3,007,813.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 34,939,350.00 | 24,824,610.00 |
| Бичиг хэргийн материал | 3,970,900.00 | 1,695,670.00 |
| Тээвэр, шатахууны зардал | 10,554,200.00 | 3,923,000.00 |
| Шуудан холбоо интернетийн төлбөр | 2,253,075.00 | 2,314,849.00 |
| Ном, хэвлэлийн зардал | 16,483,850.00 | 13,383,571.00 |
| Хог хаягдал устгах, цэвэрлэх | 606,543.00 | 1,365,000.00 |
| Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 1,070,782.00 | 2,142,520.00 |
| Нормативт зардал | 81,700.00 | 200,000.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 81,700.00 | 200,000.00 |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | |
|---|---|---|
| Эд хогшил, урсгал засварын зардал | 20,217,200.00 | 13,417,800.00 |
| Урсгал засвар | 20,217,200.00 | 13,417,800.00 |
| Томилолт, зочны зардал | 166,421,800.00 | 71,049,700.00 |
| Дотоод томилолтын зардал | 166,421,800.00 | 71,049,700.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 168,838,264.00 | 281,851,396.20 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 154,611,765.00 | 277,637,886.20 |
| Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 700,000.00 | 700,000.00 |
| Даатгалын үйлчилгээний төлбөр | 98,010.00 | 98,010.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 54,600.00 | 45,000.00 |
| Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | - | 3,370,500.00 |
| Газрын төлбөр | 13,373,889.00 | - |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 85,321,760.68 | 46,956,275.17 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 50,350,317.00 | - |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | - | 3,000,000.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 34,971,443.68 | 43,956,275.17 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | **48,513,881.00** |
| Бусад урсгал шилжүүлэг | - | 41,800,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 41,800,000.00 |
| Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 6,713,881.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 6,713,881.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **44,808,671.32** | **45,141,698.95** |
| **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **44,808,671.32** | **45,141,698.95** |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

СТ-3А

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | ҮЗҮҮЛЭЛТ | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,088,924,429.00** | **2,102,285,447.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **36,150,416.00** | **7,904,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **36,150,416.00** | **7,904,900.00** |
| **120004** | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **36,150,416.00** | **7,904,900.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,150,416.00 | 1,904,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,052,774,013.00** | **2,094,380,547.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,828,008,200.00** | **1,787,913,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,828,008,200.00 | 1,787,913,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **199,188,040.00** | **289,046,819.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | 114,804,000.00 | 60,775,219.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 62,654,000.00 | 208,421,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 21,730,040.00 | 19,850,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **25,577,773.00** | **12,958,628.00** |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 25,577,773.00 | 12,958,628.00 |
| 134002 | **Нэр данс зөрүү** | **00.00** | **4,461,800.00** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **2,056,389,029.00** | **2,042,769,715.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,056,389,029.00** | **2,042,769,715.00** |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,056,389,029.00** | **1,994,255,834.00** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,362,795,613.00** | **1,379,010,728.00** |
| 210101 | Үндсэн цалин | 1,304,398,813.00 | 1,181,991,628.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | 139,206,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 58,396,800.00 | 57,812,800.00 |
| **2102** | **Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл** | **146,991,000.00** | **153,241,700.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 92,982,070.00 | 97,517,445.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 10,801,306.00 | 11,144,850.91 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 8,037,178.00 | 13,931,063.64 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 8,164,484.00 | 2,786,212.73 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 27,005,962.00 | 27,862,127.27 |
| **2103** | **Байр ашиглалтай  холбоотой тогтмол зардал** | **54,230,000.00** | **50,267,600.00** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 35,403,573.00 | 34,633,630.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 14,696,007.00 | 12,626,157.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 4,130,420.00 | 3,007,813.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **53,256,000.00** | **36,976,927.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,928,900.00 | 1,524,670.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,554,200.00 | 3,928,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,253,075.00 | 2,314,849.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 34,292,500.00 | 25,438,978.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 606,543.00 | 1,365,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,620,782.00 | 2,405,430.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **900,000.00** | **899,000.00** |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 900,000.00 | 899,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,217,200.00** | **16,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 20,217,200.00 | 16,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **167,421,800.00** | **71,401,900.00** |
| 210701 | Дотоод албан томилолт | 167,421,800.00 | 71,401,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **186,432,099.00** | **283,462,979.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 169,205,600.00 | 279,249,469.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 700,000.00 | 700,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 98,010.00 | 98,010.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 54,600.00 | 45,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,000,000.00 | 3,370,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 13,373,889.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **64,145,317.00** | **3,000,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 64,145,317.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | - | 3,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | **48,513,881.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | **41,800,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | - | 41,800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | **6,713,881.00** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 6,713,881.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **32,535,400.00** | **59,515,732.00** |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **24,601,400.00** | **59,515,732.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **24,601,400.00** | **59,515,732.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **24,601,400.00** | **59,515,732.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 24,601,400.00 | 59,515,732.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(24,601,400.00)** | **(59,515,732.00)** |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **7,934,000.00** | **-** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**СТ-4А**

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*/төгрөгөөр/*

| ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| ДАНС | 511 | 51300 | 51210+51220 | |
| **2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | **1,839,580,969.39** | **1,114,386,219.32** | **(1,744,622,598.16)** | **1,209,344,590.55** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,839,580,969.39 | 1,114,386,219.32 | (1,744,622,598.16) | 1,209,344,590.55 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | | | | |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | | | | |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | | | 44,808,671.32 | 44,808,671.32 |
| **2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,839,580,969.39** | **1,114,386,219.32** | **(1,699,813,926.84)** | **1,254,153,261.87** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,839,580,969.39 | 1,114,386,219.32 | (1,699,813,926.84) | 1,254,153,261.87 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | - | - | - | - |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 45,141,698.95 | 45,141,698.95 |
| **2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,839,580,969.39** | **1,114,386,219.32** | **(1,654,672,227.89)** | **1,299,294,960.82** |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

# АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,795,413,300.00** | **1,789,186,537.00** | **6,226,763.00** | **99.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **1,795,413,300.00** | **1,789,186,537.00** | **6,226,763.00** | **99.65** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **1,748,013,300.00** | **1,747,386,537.00** | **626,763.00** | **99.96** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,351,306,100.00** | **1,351,306,100.00** | **-** | **100.00** |
| 210101 | Үндсэн цалин | 1,154,287,000.00 | 1,154,287,000.00 | - | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 139,206,300.00 | 139,206,300.00 | - | 100.00 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 57,812,800.00 | 57,812,800.00 | - | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **153,857,700.00** | **153,241,700.00** | **616,000.00** | **99.60** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 98,178,095.99 | 97,517,445.45 | 660,650.54 | 99.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,085,520.99 | 11,144,850.91 | (59,329.92) | 100.54 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 13,935,651.01 | 13,931,063.64 | 4,587.37 | 99.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,787,130.01 | 2,786,212.73 | 917.28 | 99.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,871,302.00 | 27,862,127.27 | 9,174.73 | 99.97 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **50,267,600.00** | **50,267,600.00** | **-** | **100.00** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 21,820,000.00 | 34,633,630.00 | (12,813,630.00) | 158.72 |
| 210302 | Түлш, халаалт | 25,120,000.00 | 12,626,157.00 | 12,493,843.00 | 50.26 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,327,600.00 | 3,007,813.00 | 319,787.00 | 90.39 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **26,855,000.00** | **26,854,927.00** | **73.00** | **100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 600,000.00 | 726,070.00 | (126,070.00) | 121.01 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 1,140,000.00 | 1,140,000.00 | - | 100.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 4,800,000.00 | 2,314,849.00 | 2,485,151.00 | 48.23 |
| 210404 | Ном, хэвлэл | 19,710,000.00 | 19,703,578.00 | 6,422.00 | 99.97 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 505,000.00 | 1,365,000.00 | (860,000.00) | 270.30 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 100,000.00 | 1,605,430.00 | (1,505,430.00) | 1,605.43 |
| **2105** | **Нормативт зардал** | **700,000.00** | **699,000.00** | **1,000.00** | **99.86** |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 700,000.00 | 699,000.00 | 1,000.00 | 99.86 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **56,000,000.00** | **56,000,000.00** | **-** | **100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 40,000,000.00 | 40,000,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,000,000.00 | 16,000,000.00 | - | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **27,624,200.00** | **27,624,200.00** | **-** | **100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 27,624,200.00 | 27,624,200.00 | - | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **78,402,700.00** | **78,393,010.00** | **9,690.00** | **99.99** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 74,550,000.00 | 74,550,000.00 | - | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 700,000.00 | 700,000.00 | - | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 98,100.00 | 98,010.00 | 90.00 | 99.91 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 54,600.00 | 45,000.00 | 9,600.00 | 82.42 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.00 |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,000,000.00** | **3,000,000.00** | **-** | **100.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.00 |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **47,400,000.00** | **41,800,000.00** | **5,600,000.00** | **88.19** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **47,400,000.00** | **41,800,000.00** | **5,600,000.00** | **88.19** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 47,400,000.00 | 41,800,000.00 | 5,600,000.00 | 88.19 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,795,413,300.00** | **1,789,186,537.00** | **6,226,763.00** | **99.65** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,787,913,300.00** | **1,781,281,637.00** | **6,631,663.00** | **99.63** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,787,913,300.00 | 1,781,281,637.00 | 6,631,663.00 | 99.63 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **7,500,000.00** | **7,904,900.00** | **(404,900.00)** | **105.40** |
| 1200041 | Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,000,000.00 | 6,000,000.00 | - | 100.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,500,000.00 | 1,904,900.00 | (404,900.00) | 126.99 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **158.00** | **158.00** | **-** | **100.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 133.00 | 133.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 24.00 | 24.00 | - | 100.00 |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 0.0 | **288,964,601.00** | (288,964,601.00) | 0% |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 0.0 | **288,964,601.00** | (288,964,601.00) | 0% |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.0 | **288,964,601.00** | (288,964,601.00) | 0% |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0.0 | **14,746,000.00** | (14,746,000.00) | 0% |
| 210101 | Үндсэн цалин | 0.0 | 14,746,000.00 | (14,746,000.00) | 0% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.0 | **8,381,600.00** | (8,381,600.00) | 0% |
| 210401 | Бичиг хэрэг | 0.0 | 798,600.00 | (798,600.00) | 0% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.0 | 1,783,000.00 | (1,783,000.00) | 0% |
| 210404 | Ном, хэвлэл | 0.0 | 5,000,000.00 | (5,000,000.00) | 0% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0.0 | 800,000.00 | (800,000.00) | 0% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 0.0 | **43,777,700.00** | (43,777,700.00) | 0% |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.0 | 43,777,700.00 | (43,777,700.00) | 0% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.0 | **222,059,301.00** | (222,059,301.00) | 0% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.0 | 222,059,301.00 | (222,059,301.00) | 0% |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.0 | **288,964,601.00** | (288,964,601.00) | 0% |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.0 | **288,964,601.00** | (288,964,601.00) | 0% |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 0.0 | 60,775,219.00 | (60,775,219.00) | 0% |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.0 | 195,921,000.00 | (195,921,000.00) | 0% |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.0 | 32,268,382.00 | (32,268,382.00) | 0% |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | - | - | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 57.00 | 57.00 | - | 100% |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 48.00 | 48.00 | - | **100%** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.00 | 8.00 | - | **100%** |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ